



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар A/578

Улаанбаатар хот

Г 7  
Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.13 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" 360 дугаар тогтоол, "Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Л.Цэдэвсүрэн), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/61 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН





Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн  
15.18.. дугаар тушаалтын хавсралт

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР,  
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР, ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН  
ХЭЛТСИЙН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймаг, нийслэлийн Боловсролын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360, 377 дугаар тогтоолд зааснаар нийслэлд “Боловсролын газар”, аймагт “Боловсрол, шинжлэх ухааны газар” байна.

1.2. Аймаг, нийслэлийн Боловсролын газар (цаашид “газар” гэх), нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс (цаашид “хэлтэс” гэх)-ийн бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу нийслэлийн Боловсролын газар нь дүүргийн боловсролын хэлтсийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэгээр хангаж ажиллана.

1.4. Газар, хэлтэс нь үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, эрх бүхий этгээдийн баталсан шийдвэр, зөвлөмж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Үйл ажиллагаандын баримтлах зарчим**

2.1. Газар, хэлтэс нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна дараах зарчмыг баримтална:

2.1.1.хүний эрхийг дээдэлсэн, хүн бүрд тэгш хүртээмжтэй, тэгш боломжийг олгосон чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх;

2.1.2.багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих;

2.1.3.насан туршдаа суралцахуйг дэмжих;

2.1.4. хувь хүний эрх, хэрэгцээ шаардлагад нийцсэн, нээлттэй, уян хатан, тасралтгүй, сургалтын арга зүй, технологи хөгжүүлэх;

2.1.5.зайн болон цахим боловсрол, сургалтын уян хатан хэлбэрийг дэмжих;

2.1.6.чадахуйн зарчимд суурилсан удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;

2.1.7.чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилах;

2.1.8.шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хангах.

**Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

3.1. Газар, хэлтэс нь Боловсролын ерөнхий хуулийн 28.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд төлөвлөх, зохион байгуулах чиглэлээр:

3.1.1.1.боловсрол, шинжлэх ухааны салбарын хөгжлийн бодлого, хууль, тогтоомж шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөө, гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

3.1.1.2.шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт болон цаг үеийн бусад асуудлаар орон нутгийн сургалтын болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, олон нийтэд мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх, үр дүн, гүйцэтгэлийг тайлагнах;

3.1.1.3.аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн Засаг дарга нарт Боловсролын ерөнхий хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд болон Засаг даргын дэргэдэх орон нутаг дахь Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлд шийдвэр, зөвлөмж гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

3.1.1.4.орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, бүс нутгийн онцлог, хүн амын нягтрал, хэтийн төлөв, цэцэрлэг, сургуулийн барилгын хүчин чадал, нөөцийг харгалzan Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойрог тогтоох, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах, хяналт тавих;

3.1.1.5.салбарын хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн явцын мэдээлэл нэгтгэх, хяналт тавих, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын цахим төсвийн системийг удирдах, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, батлагдсан төсвийн санхүүжилтийг зохион байгуулах, удирдах, хянах, гүйцэтгэлийг хянах, судалгаа тооцоо хийх, нэгтгэх, орон нутагт бүх төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн мэдээ, тайланг гаргах;

3.1.1.6.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, хүний нөөцийн хангалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж, орон нутгийн онцлогт тохирсон хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх, боловсролын сургалтын байгууллагын туслах аж ахуйг хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, оролцогч талуудад хоол шим тэжээлийн боловсрол олгох, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.1.1.7.сургалтын үйл ажиллагаанд хөтлөх сургалтын баримт бичиг болон багш, суралцагчийг сурх бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, тайлагнах;

3.1.1.8.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасан боловсролын баримт бичиг олгохтой холбогдох асуудлын хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих, тайлагнах;

3.1.1.9.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын статистикийн мэдээлэл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд хүргэх;

3.1.1.10.боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем (багш, ажилтан, суралцагч, боловсролын сургалтын байгууллага, түүний орчны мэдээллийн бүртгэл бүхий)-ийг бүрдүүлж, хөгжүүлэхэд цэцэрлэг, сургууль, мэргэжлийн

боловсролын сургууль, политехник коллежид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах;

**3.1.2. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах, боловсролын сургалтын байгууллага, багш, ажилтан, иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах чиглэлээр:**

3.1.2.1. сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааг зохион байгуулахад орон нутгийн боловсролын сургалтын байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.2.2. ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх, суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, төрөлжсөн сургалт зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

3.1.2.3. сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын насын хүүхэд, залуусыг боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, үр дүнг хянаж, сайжруулах;

3.1.2.4. цэцэрлэг, сургуулийн насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг оношилгоог холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, тохируулгат орчин бүрдүүлэх, хэл, соёлын ялгаатай хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт, суралцахуйн явц, үр дүнгийн талаар судалгаа хийж, сурлагын хоцрогдол нөхөх, тэгш хамруулах, холбогдох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах;

3.1.2.5. иргэдийн насан туршийн суралцахуйд дэмжлэг үзүүлэх, насан туршийн суралцахуйн төв, сургалтын байгууллагад арга зүйн дэмжлэг үзүүлэх, суралцах боломжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг тандах судалгаа, оношилгоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, үр дүнг мэдээлэх, үр дүнд суурилан үйл ажиллагаа төлөвлөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах арга хэмжээ авах;

3.1.2.6. боловсролын сургалтын байгууллагын болон дотуур байрны орчинд суралцагчийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх, хөгжил төлөвшил, авьяасыг хөгжүүлэх, нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, оролцоог хангах чиглэлээр секц, дугуйлан, клубийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэдний өөрөө удирдах байгууллагаар дамжуулж, багаар ажиллах, хамтран суралцах арга зүйд суралцахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллах, багш, ажилтныг арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;

3.1.2.7. цахим сургалтын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын байгууллагын цахим дэд бүтэц, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, оновчтой зохион байгуулах чиглэлээр зөвлөмж өгөх, дэмжих;

3.1.2.8. гамшигийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийх, үр дүнд үндэслэн хувилбарт боломжуудыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу боловсруулах, төлөвлөгөө гаргах,

шуурхай арга хэмжээ авч, холбогдох мэдээллээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хамtran ажиллах;

**3.1.2.9.багш, суралцагчдын дунд эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах;**

**3.1.3.Багш, ажилтны хүний нөөцийн хөгжлийг орон нутгийн түвшинд төлөвлөх, зохион байгуулах, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:**

**3.1.3.1.орон нутгийн боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны явц болон үр дүнд хяналт шинжилгээ хийх, зөвлөмж өгөх, санал гаргах, үндэсний болон бүсийн багшийн хөгжлийн төв, мэргэжлийн багуудтай хамtran ажиллах, дэмжлэг үзүүлэх, боловсролын сургалтын байгууллага болон багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамtran зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;**

**3.1.3.2.боловсролын сургалтын байгууллагуудын зохион байгуулж буй сургалт, мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, уялдааг хангах, багш, ажилтан ажлын байрандаа хөгжих, менторыг ажиллуулах, харилцан туршлага солилцох, бүтээлч үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг хөгжүүлэх, тэдний шилдэг арга зүй, технологийг боловсролын технологийн санд бүртгэж, түгээн дэлгэрүүлэх, урамшуулах;**

**3.1.3.3.Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасан боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон мэргэжил, арга зүйн удирдлага, багшийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэшлийн зөвлөгөө, арга зүйн удирдлагаар хангах, багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамtran ажиллах;**

**3.1.3.4.орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг эрэлтэд суурилан богино болон дунд хугацаанд төлөвлөх, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх, багш, удирдах ажилтныг Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.14 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэн ажиллуулах, багш бэлтгэх их, дээд сургуулийн тэгсөх ангийн шаардлага хангасан суралцагчийг дагалдан багшаар ажиллуулах, зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах;**

**3.1.3.5.боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаас зохион байгуулах үнэлгээнд дэмжлэг үзүүлэх, хамtran ажиллах, орон нутаг болон боловсролын сургалтын байгууллагын түвшинд үнэлгээний чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамtran ажиллах, боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтнуудад арга зүйн дэмжлэг үзүүлэх;**

**3.1.3.6.нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хууль, Боловсролын ерөнхий хуульд заасан шалгуурт нийцүүлэн, Төрийн албаны зөвлөлөөс**

баталсан журамд заасны дагуу зохион байгуулах, томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, дүнг ил тод, нээлттэй мэдээлэх;

3.1.3.7.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны нийгмийн асуудлаар судалгаа хийх, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтад заасны дагуу нийгмийн баталгааг хангуулах санал боловсруулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

**3.1.4.Боловсролын сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих, үнэлэх, сайжруулах арга хэмжээг орон нутгийн түвшинд зохион байгуулах чиглэлээр:**

3.1.4.1.боловсролын сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, боловсролын чанарыг сайжруулахад өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, политехник коллежийг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах;

3.1.4.2.Боловсролын ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль үүсгэн байгуулах, өөрчлөх асуудлаар сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас магадлан шалгах ажиллагаанд оролцох, дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллах;

3.1.4.3.төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжүүлж буй гадаад улсын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд хуульд заасан холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

3.1.4.4.боловсролын сургалтын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, утасгүй дотоод сүлжээний болон цахим сургалтын орчныг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.4.5.боловсролын сургалтын байгууллагад тэгш хамруулах орчныг бүрдүүлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад саналаа хүргүүлэх, холбогдох судалгаа мэдээллээр хангах, хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх, иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцах, бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшихэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.4.6.аймаг, дүүргийн хэмжээнд боловсролын үйлчилгээнд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын сургалтын байгууллагад холbon зуучлах үүрэг бүхий "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн хурлыг зохион байгуулж, зарлан хуралдуулах арга хэмжээ авч ажиллах;

3.1.4.7.газарзүйн мэдээллийн системийн орон зайн дүн шинжилгээнд тулгуурлан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх хэрэгцээ, шаардлагыг элсэлтийн болон хүн амын өсөлтийн байдал, шилжилт, хөдөлгөөний чиг хандлага, нутаг орны хөгжлийн төлөвлөлт зэрэг олон талын хүчин зүйлсийг харгалзан цэцэрлэг, сургуулийн байршил, бүтэц, хэв шинжийг оновчтой тогтоох, өөрчлөн байгуулах, цэцэрлэг, сургуулийн ачааллын тэнцвэрт байдлыг хангах, дахин төлөвлөлт хийх, санал боловсруулж Боловсролын ерөнхий газарт хүргүүлэх;

3.1.4.8.орон нутгийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын сургалтын чиглэл, хөтөлбөрийг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн

эрэлттэй нийцүүлэн тодорхойлоход орон нутгийн төрийн байгууллага, ажил олгогч, мэргэжлийн зөвлөлтэй хамtran боловсруулах, түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх, төгсөгчийн хөдөлмөр эрхлэхэд орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагатай хамtran ажиллах;

3.1.4.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай хамtran зохион байгуулах, үр дүнг үйл ажиллагаандаа тусган мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, үр дүнг тайлагнах;

3.1.4.10.боловсролын сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлын болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй байдалд мэргэжлийн байгууллага, олон нийт, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тавих хяналтыг тогтмолжуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хүчирхийлэл, гэмт хэрэг, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах;

3.1.4.11.орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын орчинд хүүхэдтэй зүй бус харилцах хандлага гаргахгүй байх, ёсвөр үеийнхнийг дарамт, дээрэлхэлт, хүүхэд, залуучууд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд /цахим орчин, согтуурах, мансуурах, донтох байдалд/ өртөхгүй байх болон хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн судалгаанд сууринсан нөлөөллийн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамtran тогтмол зохион байгуулах;

3.1.4.12.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын уялдаа холбоог хангах, сайн туршлага, бүтээлч ажлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;

### **3.1.5. Стандарт, техникийн зохицуулалт, хэрэгжилт, эрх зүйн бичиг баримтын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах чиглэлээр:**

3.1.5.1.боловсролын сургалтын байгууллага, удирдлага, багш болон бусад ажилтан, албан хаагчдын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоо төлөвшүүлэх ажлыг арга зүйн удирдамжаар хангаж зөвлөн туслах, хамtran ажиллах, олон нийтийн оролцоог хангах, зөвлөн туслах, үр дүнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.5.2.өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх;

3.1.5.3.төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын чиг үүргийг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж ажиллах;

3.1.5.4.Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу аймаг, нийслэлийн хэмжээнд холбогдох хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийх, их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.5.5. орон нутгийн түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, хяналт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулалтаар хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулалтаар хангах;

**3.1.6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах чиглэлээр:**

3.1.6.1.орон нутагт Боловсролын ерөнхий хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Инновацийн тухай хуульд заасан шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

3.1.6.2.аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд орон нутаг дахь Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөл байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын төлөвлөгөөтэй уялдуулах, шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах, хэрэгжүүлэх;

3.1.6.3.шинжлэх ухаан, технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх орон нутгийн бодлого, арга хэмжээ, төлөвлөгөө, нийтлэг зохицуулалтын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга болон Засаг даргын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл шийдвэр, зөвлөмж гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, гүйцэтгэлийг тайлагнах;

3.1.6.4.шинжлэх ухаан, технологи, инновацийн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангахад шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах;

3.1.6.5.орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дунд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалт, зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх;

3.1.6.6.орон нутгийн иргэдийн санал санаачилгыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд гарааны санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;

3.1.6.7.орон нутгаас төрөн гарсан эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, орон нутгийн шийдвэрлэх асуудалд шинжлэх ухааны зүгээс үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаа, шинжилгээнд татан оролцуулах чиглэлээр хамтран ажиллах;

3.1.6.8.орон нутагт сургалт - эрдэм шинжилгээ - үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, их, дээд сургуулийн үйл ажиллагааг орон нутгийн ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагатай холбох, суралцагчдад дадлага хийх боломжийг бүрдүүлэх, орон нутгийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын боловсролын сургалтын байгууллага болон ажил олгогч, шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдааг хангах, түншлэлийг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.6.9.аймаг, орон нутаг, бүсийн тувшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах;

3.1.6.10.аймаг, орон нутгийн онцлогт тулгуурлан байгаль, нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн контентыг бүтээж, орон нутгийн болон үндэсний олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.2. Журмын 3.1.6-д заасан чиг үүрэг нь зөвхөн аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хамаарна.

3.3. Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан ажлын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангана.

#### **Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт**

4.1. Газар, хэлтэс нь энэхүү журамд заасан чиг үүрэг, мэргэжил, арга зүйн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна.

4.2. Газар, хэлтэст эрх бүхий байгууллагаас баталсан орон тооны хязгаарт багтсан дарга, нэгжийн дарга, мэргэжилтэн, арга зүйч, улсын байцаагч, үйлчилгээний ажилтан ажиллана. Газар, хэлтсийн орон тоог Төсвийн тухай хуульд зааснаар тогтооно.

4.2.1.газрын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 23.2.3, Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, дүүргийн хэлтсийн дарга нь Төрийн жинхэнэ албаны дэс түшмэлд тавигдах шаардлага болон Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасан шаардлагыг тус тус хангасан байна.

4.2.2.газар, хэлтсийн мэргэжилтэн, арга зүйч нь бакалавр, түүнтэй адилтгах болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, үүнээс багшийн хөгжил, судлагдахуун хариуцсан мэргэжилтэн, арга зүйч нь багш мэргэжилтэй, багш, ажилтанд мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах болон багаар ажиллах ур чадвартай байх бөгөөд харилцааны соёл, ёс зүйн хэмжээг сахин ажиллана.

4.2.3.газар, хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн, арга зүйч нь хариуцсан чиг үүргийн хүрээнд багш, удирдах ажилтанд мэргэжил, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын судалгаа хийх, мэдээлэл боловсруулах зэрэг асуудлыг хэрэгжүүлнэ.

4.3. Газар, хэлтсийн дарга нь бусад хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дарга, төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.

4.4. Боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үр дүн, хүний нөөц, төсөв, санхүүгийн болон хуулиар хориглосноос бусад мэдээллийг байгууллагын цахим хуудас/мэдээллийн самбарт байршуулах замаар байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангана.

4.5. Газар, хэлтэс нь авлига авах, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.6. Газар, хэлтэс нь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль тогтоомжид нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг гадаадын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.

#### **Тав. Бусад зүйл**

5.1. Энэ журамд Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь журмын салшгүй хэсэг болно.

---оОо---